

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2010 оны 6 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Г “Говийн цэнхэр алтай ББСБ” ХХК-ийн Г  
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Говийн цэнхэр алтай ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2010 оны 4 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд сунгалтын талаарх тэмдэглэгээг 2010 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор хийлгэхийг “Говийн цэнхэр алтай ББСБ” ХХК /Ц.Балдандагва/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН